

БАТЛАВ,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН
ДЭД ДАРГА БӨГӨӨД ШТАБЫН ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ц. ГАНЗОРИГ

2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

**ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГАЛ ТҮЙМЭР
УНТРААХ, АВРАХ АНГИ, ЭРЭН ХАЙХ АВРАХ АНГИ, САЛБАР, БҮЛГИЙН ОЙ,
ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл.

1.1. Улсын Онцгой комиссын даргын 2026 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгавар Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2026 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх.

Хоёр. Зорилго.

Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар, бүлгийн хээрийн гал түймэртэй тэмцэх албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, гал түймэр унтраах дүрэм, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэхэд оршино.

**Гурав. Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах хугацаа,
хамрах хүрээ.**

Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар бүлгүүд тус удирдамжийг 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Ажлын чиглэл.

Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар бүлгүүд удирдамжийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах алба хаагч, багаж хэрэгсэл, автомашин техникийн томилгоог хийж, 1, 2 дугаар бүлгийг томилох.

4.2. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааны багаж хэрэгслийн үзлэг, шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилган, шаардлагатай засвар үйлчилгээг хийж, өнгөрсөн жил ашигласан гар багаж (троссон шүүр, хүрз, малтуур, сүх гэх мэт)-ийг шинэчлэн сайжруулж, тоо хэмжээг нэмэгдүүлэх.

4.3. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах шуурхай албаны автомашины техникийн бэлэн байдлын үзлэг, шалгалтыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчлгээг хийж, бэлтгэл бэлэн байдлыг хангах.

4.4. Үлээгч, хөрөө гэх мэт моторт багаж хэрэгслийн шатахуун, тослох материалыг тээвэрлэх зориулалтыг савыг шинэчлэх, тоо хэмжээг нэмэгдүүлэх.

4.5. Ой, хээрийн гал түймрийн голомтод холбоо зохион байгуулах техник, тоног төхөөрөмж (сансрын хөдөлгөөнт интернэт, сансрын холбооны утас, богино болон хэт богино долгионы гар станц, дахин дамжуулагч)-ид үзлэг шалгалт зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж, бэлтгэл бэлэн байдлыг хангах.

4.6. Ой, хээрийн гал түймэр унтраах арга зүй, тактикийн чиглэлээр болон Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэмд ой, хээрийн гал түймэр унтраах чиглэлээр тусгагдсан заалтуудаар танхимын сургалтыг үр дүнтэй зохион байгуулах.

4.7. Ой, хээрийн гал түймрийн голомтод холбоо зохион байгуулах жолооч холбоочин, дуудлага хүлээн авагч нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр танхимын болон хээрийн дадлага сургалтыг үр дүнтэй зохион байгуулах.

4.8. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааны штабын болон хээрийн дадлага, сургалтыг анги, салбар, бүлгийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайтар ханган, чанартай зохион байгуулж, үр дүнг тооцох.

4.9. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар гарч ажиллах шуурхай болон тусгай зориулалтын албаны автомашин, техникийн шатахууны дүүргэлтийг 80 хувиас багагүй, шатахуунаар ажилладаг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл (моторт хөрөө, үлээгч, цуравдагч, цахилгаан үүсгүүр гэх мэт)-ийн шатахууныг 100 хувь дүүргэж, зориулалтын зөөврийн шатахууны сав, нөөц шатахуунаар хангаж, бэлэн байдлыг хангах.

4.10. Орон нутгийн Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги болон Засаг даргын захирамжаар байгуулагдсан Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн бүрэлдэхүүн, автомашин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид үзлэг, шалгалт зохион байгуулж, сайн дурын хэсгийн гишүүдийг сургаж, чадавхжуулах чиглэлээр сургалт, дадлага зохион байгуулах ажлыг зохион байгуулах.

Тав. Хүрэх үр дүн.

4.1. Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах, аврах анги, салбар, бүлгийн ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ур чадвар дээшилж, автомашин техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бие бүрэлдэхүүний албаны болон хувийн бэлтгэл бэлэн байдал хангагдана.

4.3. Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн үйл ажиллагаа жигдэрч, ой, хээрийн гал түймэр унтраах мэдлэг, чадвар сайжирна.

Зургаа. Тайлан, мэдээ ирүүлэх түүнд тавигдах шаардлага.

6.1. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг, мэдээний хүснэгтийг төв, орон нутгийн Онцгой байдлын газарт нэгтгэн, албажуулж, 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор цахим хэлбэрээр /b.battuvshin@nema.gov.mn/ хаягаар ирүүлнэ. /Фото зургийг хавсаргана/

6.2. Тайланд удирдамжийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний үр дүн, ололт амжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал, дүгнэлт тусгасах.

Жич: Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэх ажлын тайланг цаасаар ирүүлэх шаардлагагүй, албажуулж, цахим шуудангаар ирүүлнэ.

Долоо. Дүгнэх талаар.

7.1. Нэгдсэн удирдамжийн хүрээнд хийгдсэн ажлын тайланг Гал түймэртэй тэмцэх газарт хүлээн авч нэгтгэн үнэлгээ, дүгнэлтийг Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын даргад танилцуулна.

7.2. Удирдамжийн хүрээнд ой, хээрийн гал түймэр унтраах арга ажиллагаа, эрсдэлийг бууруулахтай холбоотойгоор шинээр санаачилсан ажил, бүтээлч арга нэвтрүүлсэн хамт олныг урамшуулах, хангалтгүй зохион байгуулсан удирдах албан тушаалтанд холбогдох дүрэмд заасны дагуу хариуцлага тооцно.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

УДИРДАМЖИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ

д/д	Асуулга	Аймгийн нэр	
		Булган	
		ГТУА 20-р анги	ГТУА 50-р анги
1	1 дүгээр бүлэг	Алба хаагчийн тоо	
		Автомашины тоо	
		Алба хаагчийн тоо	
		Автомашины тоо	
2	2 дугаар бүлэг	Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцасны тоо	
3		Шаардлагатай ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцасны тоо	
4		Засвар хийсэн багаж хэрэгсэл	Төрөл Тоо
5		Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааны багаж хэрэгслийн засвар үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө (₮)	
6	Засвар үйлчилгээ хийсэн автомашины тоо	Шуурхай албаны	
7		Тусгай албаны	
8		Автомашины засвар үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө (₮)	
9			
10	Сургалт, дадлага	Танхимын сургалт зохион байгуулсан тоо	
11		Зохион байгуулсан цаг	
12		Сургалтад хамрагдсан алба хаагчийн тоо	
13		Штабын дадлага сургалт зохион байгуулсан тоо	
14		Зохион байгуулсан цаг	
15		Дадлага сургалтад хамрагдсан алба хаагчийн тоо	
16		Хээрийг дадлага сургалт зохион байгуулсан тоо	
17		Зохион байгуулсан цаг	
18		Дадлага сургалтад хамрагдсан алба хаагчийн тоо	
19		Холбоо зохион байгуулалтын дадлага сургалт зохион байгуулсан тоо	
20		Зохион байгуулсан цаг	
21		Дадлага сургалтад хамрагдсан алба хаагчийн тоо	
22	Багаж хэрэгслийн судалгаа	Сансрын хөдөлгөөнт интернэтийн төхөөрөмжийн тоо	
23		Сансрын холбооны утасны тоо	
24		Зөөврийн зай хураагуур (Ecoflow)	
25		Цахилгаан үүсгүүр	
26		Нарны хавтан	
27		Үлээгч	
28		Моторт хөрөө	
29		РЛО	
30		Цуравдагч	
31		Сүх	
32		Хүрз	
33		Гар хөрөө	
34		Троссон шүүр	
35		Богино долгионы станц	
		Хэт богино долгионы гар станц	
		Дахин дамжуулагч	